



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/253

Хэрлэн сум

Төсөл, арга хэмжээний
багцын санхүүжилт хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 8.7 дахь хэсэг, Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 02 дугаар сарын 10-ны “Жагсаалт батлах тухай” 32 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад XII.1.38 дугаартай батлагдсан “Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ (Хэнтий, Хэрлэн сум)” төсөл, арга хэмжээний багцад ногдох 2024 онд санхүүжих дүнг хавсралтаар баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

**“ГЭР ХОРООЛЛЫН ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ
(ХЭНТИЙ, ХЭРЛЭН СҮМ)” ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ БАГЦЫН САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРЬ**



 2024 оны 05 дугаар сарын 19-ны
 Дугаар захирамжийн хавсралт

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Багцын дугаар	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг (сая ₮)	Гэрээний дүн (төгрөг)	Санхүүжих дүн (төгрөг)		
							2022	2023	2024
1	Гэр инженерийн хорооллын шугам сүлжээ (Хэнтий, Хэрлэн сум)	1	2022	2024	50,978.9	16,793,182,269.0	3,041,200,000.0	9,137,184,000.0	4,614,798,269.0
		2	2022	2024		13,013,469,242.0	2,358,800,000.0	7,179,215,997.0	3,475,453,245.0
		3	2023	2024		21,172,222,222.0	-	2,000,0000.0	19,172,222,222.0
						50,978,873,733.0	5,400,000,000.0	18,316,399,997.0	27,262,473,736.0